



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/557

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилтыг танилцуулах, 2020-2024 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрт иргэдийн саналыг авч тусгах, малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх арга хэмжээний хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд Эрдэнэ, Чандмань, Цээл, Халиун, Цогт, Алтай, Бугат, Төгрөг сумдын 37 багт "Малчдад төрийн үйлчилгээ үзүүлэх" ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 43,942,500 (дөчин гурван сая есөн зуун дөчин хоёр мянга таван зуу) төгрөгийн зардлыг Засаг даргын ерөнхий дансны батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны
10 дугаар сарын 11-ны өдрийн 557 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Нийт үнэ
1	Шинэ ургацын жимс	16,285,500
2	Уут	2,508,000
3	Бичиг хэрэг	2,949,000
4	Бусад	22,200,000
	Нийт дүн	43,942,500

__оОо__

